

**БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН 2018 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САРД
 ХИЙХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**
 /2018.10.26-2018.11.25/

2018 оны 11 сарын 26-ны өдөр

Ховд хот

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх ажил	Биелэлт	Үнэлгээ	
				Нэгж	ДШД АХ
1	2	3	4	5	6
Нэг. Захиргаа хүний нөөц, сургалтын чиглэлээр					
1	Газрын холбогдох газар, хэлтсээс болон бусад байгууллагаас ирсэн болон байгууллагаас явсан бичиг, иргэн аж ахуй нэгж байгууллагаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч, холбогдох журмын дагуу шийдвэрлэх	а. Газарт ирсэн бичгийг бүртгэн холбогдох албан тушаалтанд шилжүүлэх б. Явсан бичигт дугаар олгож, холбогдох газарт хүргүүлэх в. Өргөдөл, гомдолыг бүртгэн холбогдох албан тушаалтанд шилжүүлэх	Тайлангийн хугацаанд Бүсийн газарт ирсэн 8 албан бичгийг удирдлагад танилцуулан бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, 22 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж ажилласан. Баруун бүс дэх газарт 2018 оны 11 дүгээр сард иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн өргөдөл байхгүй, албан хаагчдаас 4 өргөдлийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн, хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.		
2	Газар болон орон нутгаас зохион байгуулж буй урт болон богино хугацааны сургалтанд албан хаагчдыг хамруулах	Дотооддоо сургалт зохион байгуулах	Мэргэжилтэн Б.Даваасүрэн 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр олон улсын баримт бичиг, түүний хуурмаглал, баримт бичгийн хүчин төгөлдөр байх нөхцөл, хуурмаглалаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, илрүүлэлтийн талаар Бүсийн төвийн 9 албан хаагчид мэдээлэл сургалт зохион байгуулсан.		
3	Газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллах төлөвлөгөөний дагуу холбогдох ажлыг зохион байгуулах.	Гэмт хэргээс урьдчилан ажиллах төлөвлөгөөний дагуу хамтын ажиллагаатай хууль хяналтын байгууллагуудтай хамтран албан хаагчдад мэдээлэл хийх			
4	Тамгын газар болон холбогдох албан тушаалтнаас ирүүлсэн албан хаагчдын судалгаа мэдээлэлийг хүргүүлэх.	Албан хаагчдын судалгаа гаргах	Баруун бүс дэх газрын 2018 онд сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгаа, мэргэшсэн төрийн жинхэнэ албан хаагчдийн судалгаа, хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалтад хамрагдах 6 албан хаагчийн мэдээлэл зэргийг гарган хүний нөөц, сургалтын мэргэжилтэнд тус тус хүргүүлсэн.		

1	2	3	4	5	6
5	Баруун бүс дэх газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бичиг баримтыг цэгцэлж, архивын нэгж болгон хадгалах ажлыг зохион байгуулах	Баримт бичиг хүлээн авах хуваарийн дагуу стандартад нийцсэн архивын нэгж хүлээн авах	Хөтлөх нэрийн жагсаалтийн дагуу Бүсийн төвийн болон хэлтсүүдийн 2018 оны бичиг баримт, албан хаагчдаас ирүүлсэн бүртгэл хасалт, олгосон виз, зөрчлийн материал зэрэг 8 архивын нэгжийг зааврын дагуу хавтаслаж архивт хүлээн авсан.		
Хоёр . Виз зөвшөөрөл, Хяналт шалгалт, Иргэний харьяалалийн чиглэлээр					
6	Виз, бүртгэлийн чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын хилээр орох, гарах, дамжин өнгөрөх гадаадын иргэнд виз олгох, визийн шилжүүлэг хийх асуудлыг хууль тогтоомж, дүрэм, журам, байгууллагын удирдлагаас өгсөн чиглэлийн хүрээнд хуулийн дагуу зохион байгуулах, албан хаагчдын хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих	Тайлант хугацаанд 2 орны 12 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон. Үүнд: - Нэг удаагийн орох - 2 - Нэг удаагийн гарах-орох –9 - Хоёр удаагийн гарах-орох-1		
		Монгол Улсад түр ирэгч гадаадын иргэдэд бүртгэл, хасалт хийх	Тайлангийн хугацаанд нийт 4 орны 97 гадаадын иргэнийг бүртгэж, 4 орны 89 гадаадын иргэнд хасалт хийсэн. Үүнд: - АНУ-1, БНКАЗУ-79, БНХАУ-10, ОХУ-6, харьяалалгүй 1 иргэнийг тус тус бүртгэсэн. - АНУ-1, БНКАЗУ-78, БНХАУ-4, ОХУ-5, харьяалалгүй 1 иргэний бүртгэлд хасалт хийсэн байна.		
		Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр зорчигч гадаадын иргэдэд бүртгэл хасалт хийж хяналт тавих.	Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр зорчигч БНХАУ-ын 2 иргэнд бүртгэл хасалт хийж, хяналт тавьж ажилласан.		
		Монгол улсад хувийн хэргээр зорчих урилга хүссэн иргэдийн хүсэлтийг хүлээн авч холбогдох байгууллагаас санал авсны дагуу гадаадын иргэдэд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох	Тайлангийн хугацаанд урилга олгоогүй.		

1	2	3	4	5	6
		Монгол улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн гадаадын иргэний материалыг хүлээн авч төвд шилжүүлэх	ИБУИНВУ-ын 1 иргэний визийн зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч ГИХГазарт хүргүүлсэн.		
		Монгол улсад хувийн хэргээр оршин сууж байгаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрөлд хасалт хийх.	Нийт 4 орны 56 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хасалт хийж, үнэмлэхийг хураан авсан. Үүнд: - “Чайна Хуаши Энтерпрайзис” ХХК-нд хөдөлмөр эрхлэгч БНХАУ-ын иргэн-51; - “Шанхай констракшн групп Монголиа ” ХХК-нд хөдөлмөр эрхлэгч БНХАУ-ын иргэн-2; - Н5 ангиллаар оршин сууж байсан БНКаз.Улсын 1 иргэн - Н2 ангиллаар оршин сууж байсан БНКаз.Улсын 1 иргэн - TS ангиллаар оршин сууж байсан БНХАУ 1 иргэн		
		Монгол улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл хүссэн гадаадын иргэний хурууны хээг авах.	Монгол улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл хүссэн БНХАУ-ын 6, ОХУ-ын 1 иргэний гарын хурууны хээг авч баталгаажуулан, Мэдээлэл технологийн хэлтэст хүргүүлэв.		
	Виз, бүртгэлийн чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулах	Монгол улсад байх визийн хугацаа сунгуулах хүсэлт гаргасан иргэн, ААН байгууллагын хүсэлтийг хүлээн авч материалын бүрдлийг хангуулан зохих журмын дагуу бүртгэлээр 30 хүртэл хоногоор сунгах	Тайлант хугацаанд визийн сунгалт хийгдээгүй.		
7	Хяналт шалгалтын чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулах	2018 онд хяналт шалгалт хийх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бүсийн хэмжээнд хяналт шалгалтыг зохион байгуулах	2018 оны Хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу бүсийн хэмжээнд “Уул уурхай, ашигт малтмал, барилга байгууламж, дэд бүтэц үйлдвэрлэл үйлчилгээ”, “Шашин, төрийн болон төрийн бус олон улсын байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбарт” төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж батлуулан хяналт шалгалт хийсэн.		

1	2	3	4	5	6
		<p>Иргэн, ААН байгууллагаас утсаар болон амаар, холбоо мэдээллийн хэрэгслээр ирүүлсэн гомдол мэдээллийг үндэслэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулан холбогдох арга хэмжээг авч ажиллах</p>	<p>Бүсийн төв: Баруун бүс дэх газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ББ-2018/15-13 тоот “Уул уурхай, ашигт малтмал, барилга байгууламж, дэд бүтэц үйлдвэрлэл үйлчилгээ” удирдамжийн хүрээнд 3 аж ахуй нэгжид хөдөлмөр эрхэлж байгаа 2 орны 29 гадаадын иргэн хяналт шалгалтанд хамрагдах байснаас 2 орны 19 гадаадын иргэн хамрагдлаа. БНХАУ-ын 11 иргэн нь ээлжийн амралтаа авч нутаг буцсан байсан. “Шинжиан Лю Ди Ван” ХХК: Тус компанид хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй БНХАУ-ын 5 иргэдийн баримт бичигт хяналт шалгалт хийхэд илэрсэн зөрчилгүй. 2018 оны 11 сарын 20-ны өдрийн ББ-2018/15-14 тоот “Шашин, төрийн болон төрийн бус олон улсын байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбарт төлөвлөгөөт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 8 аж ахуйн нэгж 38 гадаадын иргэн хамрагдав. Шалгалтаар ирэлсэн зөрчилгүй.</p> <p>Баян-Өлгий : ГИХГ-ын Баруун бүс дэх газрын даргын 2018 оны 11 сарын 20-ны өдрийн ББ-2018/15-14 тоот төлөвлөгөөт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 2018 оны 11 сарын 21-нээс 2018 оны 11 сарын 23-ний хооронд нийт 10 аж ахуйн нэгжийн 6 орны 25 гадаадын иргэний бичиг баримтад үзлэг шалгалт хийж, тухайн аж ахуйн нэгжийн объектийн судалгааг шинэчлэв. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй. Шалгалтаар АНУ-7, Норвеги улс-4, БНТуркУлс-11, Швейцарь улс-1, Филиппин улс-1, БНКазУлс-1 иргэн тус тус хамрагдав.</p> <p>Говь-Алтай : Баруун бүс дэх газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ББ-2018/15-13 тоот “Уул уурхай, ашигт малтмал, барилга байгууламж, дэд бүтэц үйлдвэрлэл үйлчилгээ” удирдамжийн хүрээнд “Алтайн Хүдэр” ХХК-нд хяналт шалгалт хийж гүйцэтгэхэд тус компанид хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй БНИндонез Улсын 8 иргэн хамрагдсан бөгөөд эдгээр иргэд нь оршин суух зөвшөөрөл болон</p>		

1	2	3	4	5	6
			<p>2018 оны 11 сарын 20-ны өдрийн ББ-2018/15-14 тоот төлөвлөгөөт Шалгалтад Завхан аймагт “GIZ Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Политехник коллеж дээр хэрэгжүүлж байгаа төслийн удирдагч Герман улсын 1 иргэн, түүний эхнэр болох БНХАУ-ын 1 иргэн, АНУ-д төвтэй Төрийн бус олон улсын байгууллага Энхтайвны корпусын шугамаар тус аймгийн Боловсрол соёл, урлагийн газарт, Хөгжим бүжгийн коллеж, Ерөнхий боловсролын 3-р сургууль, Ерөнхий боловсролын Дэвшил сургууль гэсэн сургуулуудад сайн дурын ажилтнаар ажиллаж буй АНУ-ын 4 иргэн нийт 3 улсын 6 иргэн хамрагдсан илэрсэн зөрчилгүй байв.</p> <p>Баянхонгор: Баруун бүс дэх газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ББ-2018/15-13 тоот “Уул уурхай, ашигт малтмал, барилга байгууламж, дэд бүтэц үйлдвэрлэл үйлчилгээ” удирдамжийн хүрээнд Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт байрлах “Түмт үржин грүпп” ХХК нь одоогоор үйл ажиллагаа явуулаагүй байгаа бөгөөд гадаадын иргэд байхгүй байсан болно. Тус аймгийн Баян-Овоо сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Мэлбүри капитал” ХХК-нд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй оршин сууж буй БНГана Улсын 1 иргэн, Баянхонгор суманд барилга угсралын “Баянхонгор констракшн” ХХК-нд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй БНХАУ-ын 8 иргэн тус тус хамрагдсан бөгөөд уг иргэд нь оршин суух хаягийн талаар тогтоосон журам зөрчөөгүй, оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлээгүй паспорт түүнийг орлох бичиг баримтаа биедээ авч явсан нь тогтоогдсон, илэрсэн зөрчилгүй болно. Баянхонгор аймагт шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Баянхонгор Баптист сүм” “АНУ-ын Энхтайвны корпус” “GIZ Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага” “БНФУ-д төвтэй AVSF</p>		

1	2	3	4	5	6
		<p>Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг хуулийн дагуу шийдвэрлэх, албадан гаргах санал гаргах, гаргасан шийдвэрийг үндэслэн хууль хяналтын байгууллагуудтай хамтран албадан гаргах ажлыг зохион байгуулж танилцуулах, Хяналт шалгалтын газарт хүргүүлэх</p>	<p>/ОУБ/ болон 1,2,3, дугаар сургууль болон МСҮТ сургуулиудад ажиллаж амьдарч буй АНУ-5 БНСУ-4 БНГУ-1 БНФУ-1 нийт 11 гадаадын иргэн хяналт шалгалтанд хамрагдаж оршин суух хаягийн талаар тогтоосон журам зөрчөөгүй, оршин суух зөвшөөрөл болон визийн хугацаа хэтрүүлээгүй, визийн ангилал нь ирсэн зорилгодоо нийцэж байгаа ба паспорт түүнийг орлох бичиг баримтаа биедээ авч явсан нь тогтоогдсон, илэрсэн зөрчилгүй байлаа.</p> <p>Булган боомт: Монгол Улсад байх визийн хугацааг хэтрүүлсэн БНХАУ-ын 2 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2.4.3 дахь заалтыг үндэслэн тус бүр торгосон.</p> <p>Говь-Алтай: Монгол Улсад байх визийн хугацааг хэтрүүлсэн БНХАУ-ын нэр бүхий 3 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2.4.3 дахь заалтыг үндэслэн тус бүр торгосон.</p> <p>Баян-өлгий: Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн АНУ-ын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2.1.1 дахь заалтыг үндэслэн тус бүр торгосон. БНХАУ-ын иргэн /Sun Qiang/-ийг хууль тогтоомжид заасан хугацаанд зохих байгууллагад бүртгүүлээгүй "Чайна Хуаши Энтерпрайзиз" ХХК-ийг Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 2.500.000 төгрөгөөр торгож, шийтгэл оногдуулсан. Баримт бичиг биедээ авч явах журам зөрчсөн БНХАУ-ын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2.1.3-д зааснаар 100.000 төгрөгөөр торгож, шийтгэл оногдуулсан. Визийн хугацааг 31 хоногоор хэтрүүлсэн БНКаз.Улсын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 16.2.3.3-д зааснаар 310.000 төгрөгөөр торгож, шийтгэл оногдуулсан. Оршин суух хугацааг 149 хоногоор хэтрүүлсэн БНКаз.Улсын 1 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн</p>		

1	2	3	4	5	6
			<p>16.2.3.2-т зааснаар 1.490.000 төгрөгөөр торгож, шийтгэл оногдуулсан.</p> <p>Тайлант хугацаанд БНКаз.Улсын 1 иргэнийг Монгол улсаас албадан гаргасан.</p> <p>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол улсад дахин оруулахгүй байх хугацаа тогтоох журам”-ын 3.2.1-д заасан үндэслэлээр байгууллагын даргын 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/344 дугаар тушаалаар Монгол Улсаас 1 жилээр албадан гаргагдсан БНКаз.Улсын иргэн Avdullayeva Tolkun /N10044833 дугаарын паспорттай/-ыг 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 16 цаг 14 минутанд Цагааннуур боомтоор албадан гаргаж, албадан гаргасан тодорхойлолтыг ГИХГ-т хүргүүлсэн.</p> <p>Визийн хугацаа 149 хоног хэтрүүлсэн БНКаз.Улсын иргэн Maratbek Aitugan нь өнөөдрийн байдлаар Монгол Улсын харьяатаас гараагүй, хоёрдмол харьяалалтай тул ГИХГ-ын дэд даргад илтгэх хуудсаар танилцуулж, Монгол Улсаас албадан гаргах арга хэмжээнээс чөлөөлүүлсэн.</p>		
8	Иргэний харьяалалын чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах	Монгол Улсын харьяат болох, Харьяатаас гарах, Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох зэрэг хүсэлт гаргасан гадаадын иргэний хүсэлтийг хүлээн авч бүрдүүлэх материалын бүрдлийг хангуулан Иргэний харьяаллын газарт шилжүүлэх	Монгол Улсын харьяатаас гарах 4 өрхийн 9 хүний бүрдүүлсэн өргөдөл материалыг хянан, арга зүйн зөвлөгөө өгсөн. Монгол Улсын иргэний харьяалал сэргээн тогтоолгох 3 өрхийн 3 хүний өргөдөл материалын бүрдлийг хангуулан хүлээн авсан		
		Иргэний харьяаллын чиглэлээр өргөдөл, хүсэлт хүлээн авч холбогдох лавлагааг гаргаж өгөх	Иргэний харьяаллын чиглэлээр лавлагаа хүссэн 11 өргөдөл хүлээн авч, холбогдох лавлагааг олгосон.		

1	2	3	4	5	6
		Түр ирэгч БНКаЗУ-ын иргэдийг бүртгэх явцад хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг тогтоон анкет бөглүүлэн авч өргөдөл материалыг бүрдүүлэн мэдээллийн санд баяжилт хийн материалыг Иргэний харьяаллын газарт хүргүүлэх	Бүсийн төвд: Хоёрдмол харьяалал үүсгэсэн БНКаЗУлсын 1 иргэнийг илрүүлэн гадаадын иргэний нэгдсэн ISM программ-д бүртгэсэн.		
Гурав.Санхүү, Хангалт үйлчилгээ					
9	Төсвийн болон санхүүгийн тайланг гаргах. Татвар, Нийгмийн даатгалтай тооцоо нийлж, шилжүүлэг хийх	Харилцан хамтын ажиллагаатай байгууллагуудтай тооцоо нийлэн холбогдох гүйлгээ хийх	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган 2018 оны 11 дүгээр сарын 05-ны дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн ба ХАОАТ-ын тайлан, цалин хөлснөөс суутгасан ашгийн тайланг мөн сарын 15-ны өдөр гарган Ховд аймгийн татварт хүргүүлэн тооцоо нийлж ажилласан.		
10	Үнэт цаасны тайланг гаргах	Үнэт цааны тайланг гарган холбогдох хэлтсүүдээс нэгтгэн авах. Тэмдэгтийн хураамж болон хүү торгуулийн орлоготой тулгалт хийх	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, үнэт цаас болон хүү торгууль, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг энэ оны 11 дүгээр сарын 05-ний дотор гарган, хүү торгууль 2,450,000 төгрөг, тэмдэгтийн хураамж 360,000 төгрөгөөр тайланг нэгтгэн Хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлж Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.		
11	Шаардлагатай бараа материалын татан авалт хийх	Албан хаагчдаас ирсэн шаардах хуудасны дагуу бараа материалын татан авалтыг хийх	Албан хаагчдад үнэт цаасыг шаардах хуудасны дагуу олгосон ба авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолоочтой тооцоо нийлэн дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөн ажилласан. Албан хаагчдаас ирүүлсэн шаардах хуудасны дагуу 790000 төгрөгний бичиг хэргийн материал, 80000 төгрөгний цэвэрлэгээний материалын татан авалт хийгдсэн. Түлш шатах тослох материалд 2,916,000 төгрөгний зарцуулалт гаргаж тайлагнасан. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд Цагааннуур боомтод 480.000 төгрөгийн үнэ бүхий, Арцсуурь боомтод 468,000 төгрөгийн үнэ бүхий, Тэс боомтод		

1	2	3	4	5	6
			980,000 төгрөгийн үнэ бүхий түлээ нүүрсээр тус тус хангаад байна.		
12	Шилэн дансны вэб сайтын мэдээлэл шинэчлэх.	Шилэн дансны вэб сайтад 2018 оны 08 дугаар сарын мэдээллийг оруулах.	Бүсийн газрын төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг ханган ажилладаг бөгөөд Шилэн дансанд мэдээллээ 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор оруулж, олон нийтэд Баруун бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагааны талаарх байршуулан ажилласан.		
Дөрөв. Сүлжээ, программ хангамж					
13	Бүс, хэлтсийн бүртгэлийн программ, сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, эвдрэл, гэмтэл саатал гарсан тухай бүр нь бүртгэлд авч, засварлах.	Газраас ирүүлсэн техник, төнөг төхөөрөмжийн хувиарлалтыг хийж бүртгэлжүүлэн ажиллах.	Хэлтэс, хилийн боомтуудын компьютер, тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. Баруун бүс дэх газрын танилцуулга, ажлын байр болон объектын судалгааг шинэчлэн гаргасан.		
14	Газрын даргын 2018 оны 02 албан даалгаврын хүрээнд Бүсийн газрын холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд оруулах.	Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээлэл оруулах	Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Баруун бүсийн газрын 2018 оны 10 дугаар сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 11 дүгээр сарын төлөвлөгөө зэргийг 2018.10.29-ны өдөр байгууллагын цахим сайтад байршуулсан.		
Тав. Бусад					
15	Нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	Нийт албан хаагчдыг орон нутаг болон байгууллагаас зохион байгуулах арга хэмжээнд нийтээр нь оролцуулах	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2018 оны 265/72 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын удирдамж" –ийн дагуу хариуцсан хэсгийн аймаг, хилийн боомтуудад шалгалт хийгдэж, Баруун бүсийн газар, хэлтсүүдийн үйл ажиллагаа, төрийн захиргааны нийт 24 албан хаагч хууль, компьютерийн сорилд болон албан хаагч тус бүртэй хийсэн ярилцага шалгалтад хамрагдсан байна.		

1	2	3	4	5	6
16	Бүтээлч ажил ажил	Амьжиргааны түвшин доогуур амьдралтай нэг өрхөд түлээ нүүрсээр туслах	Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн нийт албан хаагчид бүтээлч ажлын хүрээнд амьжиргааны түвшин доогуур амьдралтай нэг өрхөд түлээ нүүрсний туслалцаа үзүүлсэн. Мөн Баруун бүсийн төвийн 16 албан хаагч Ховд аймгийн бяцхан иргэн М.Мөнхжаргал охины “Халуун сэтгэл” аянд нэгдэн туслалцаа үзүүлсэн байна.		

ТАНИЛЦСАН:

БАРУУН БІС ДЭХ ГАЗРЫН
ДАРГА

Г.ЭРДЭНЭЗАЯА

ХЯНАСАН:

ХЯНАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

А.ХУАНБАЙ

ТӨЛӨВЛӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Б.СУГАРЧИМЭГ